



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БНА-2026/184/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2026.02.25

2026

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Ахлах аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2026.02.24 № 2/56

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Ерөнхий гэрээгээр 16 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, 144,589.8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт хийсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

6426050193

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-
албан тоот.docx

Эрүүл мэндийн даатгалын сангаас Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн системийн 21 байгууллага 2025 оны эхэнд 4,308,391.3 мянган төгрөгийн авлагатай, тайлант онд 39,339,047.3 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор тооцоноос 39,764,387.2 мянган төгрөгийг санхүүжилт авч тайлант оны эцэст 3,883,051.4 мянган төгрөгийн авлагатай байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг. Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	573,273,781.05	201,589,775.77
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,678,500.00	00.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,678,500.00	00.00
3121	Төгрөг	3,678,500.00	00.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	3,678,500.00	00.00
33	АВЛАГА	183,865,201.54	8,590,432.16
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	265,713.00	265,713.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	180,488,171.54	6,943,799.00
335	Бусад авлага	3,111,317.00	1,380,920.16
3351	Байгууллагаас авах авлага	3,111,317.00	1,380,920.16
34	УРЬДЧИЛГАА	2,000,000.00	287,608.00
34600	Урьдчилж гарсан зардал	2,000,000.00	287,608.00
35	БАРАА МАТЕРИАЛ	383,730,079.51	192,711,735.61
351	Түүхий эд материал	243,488,769.74	147,063,233.36
35110	Тусгай зориулалттай материал	22,850,527.91	21,533,480.16
35130	Эм боох материал	220,638,241.83	125,529,753.20
354	Хангамжийн материал	140,241,309.77	45,648,502.25
35410	Бичиг хэргийн материал	2,413,500.00	2,111,800.00
35420	Аж ахуйн материал	14,078,594.00	10,960,687.00
35430	Сэлбэг хэрэгсэл	550,000.00	3,410,000.00
35440	Түлш, шатах тослох материал	545,223.18	1,312,421.35
35450	Барилгын засварын материал	10,227,880.00	10,344,880.00
35460	Хүнсний материал	101,672,557.95	15,668,369.85
35470	Бусад хангамжийн материал	10,753,554.64	1,840,344.05
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	931,239,790.99	1,015,640,260.64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	931,239,790.99	1,015,640,260.64
392	Биет хөрөнгө	766,321,040.93	850,859,010.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	817,117,098.51	815,290,873.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	-173,253,372.46	-199,998,338.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	113,700,000.00	282,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-111,366,666.90	-126,374,999.97
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	337,003,421.51	206,730,231.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	-231,467,450.34	-138,029,860.84
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	103,414,580.34	55,690,588.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	-89,186,569.73	-45,509,483.30
39214	Бусад үндсэн хөрөнгө	420,000.00	360,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-60,000.00	00.00
393	Биет бус хөрөнгө	164,918,750.06	164,781,250.10
39301	Програм хангамж	1,760,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,416,249.94	-343,749.90
39303	Бусад биет бус хөрөнгө	164,575,000.00	164,575,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,504,513,572.0	1,217,230,036.41

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

		4	
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,805,093.14	5,235,135.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,805,093.14	5,235,135.00
413	Өглөг	9,805,093.14	5,235,135.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	8,388,193.14	00.00
4136	Бусад өглөг	1,416,900.00	5,235,135.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,416,900.00	4,391,841.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	843,294.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,494,708,478.90	1,211,994,901.41
51	Засгийн газрын хувь оролцоо	1,494,708,478.90	1,211,994,901.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	755,146,079.04	755,146,079.04
51101	Өмч: - төрийн	755,146,079.04	755,146,079.04
512	Хуримтлагдсан үр дүн	-16,626,409.09	-297,806,961.32
51210	Өмнөх үеийн үр дүн	-16,626,409.09	-15,093,383.83
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-282,713,577.49
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	756,188,808.95	754,655,783.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,504,513,572.04	1,217,230,036.41

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,331,699,513.16	4,797,692,987.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	701,329,766.66	631,544,645.11
120	Нийтлэг татварын бус орлого	701,329,766.66	631,544,645.11
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,630,369,746.50	4,166,148,342.53
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,449,862,806.00	3,969,823,741.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,449,862,806.00	3,969,823,741.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	180,506,940.50	196,324,601.53
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	31,014,900.00	31,106,136.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	61,144,990.50	37,811,511.03
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,156,400.00	123,258,954.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,190,650.00	4,148,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,995,552,305.91	4,898,238,650.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,995,552,305.91	4,898,238,650.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,447,433,107.01	2,497,779,743.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,201,062,889.03	1,345,857,241.83
210101	Үндсэн цалин	643,263,935.43	723,630,581.27
210102	Нэмэгдэл	348,451,303.60	399,778,080.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	89,790,000.00	90,510,000.00
210104	Урамшуулал	119,557,650.00	131,938,580.00

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,866,235.25	160,040,018.05
210201	Тэтгэврийн даатгал	102,682,259.80	109,036,957.58
210202	Тэтгэмжийн даатгал	12,206,121.34	12,612,117.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,427,326.84	7,913,080.18
210204	Ажилгүйдлийн даатгал	5,910,103.40	6,095,572.70
210205	Эрүүл мэндийн даатгал	23,640,423.87	24,382,290.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,734,652.26	112,856,546.87
210301	Гэрэл, цахилгаан	8,062,484.26	8,638,322.87
210302	Түлш, халаалт	65,978,880.00	63,344,952.00
210303	Цэвэр, бохир ус	20,693,288.00	40,873,272.00
2104	Хангамж, бараа материалын зардал	69,251,050.20	147,299,418.28
210401	Бичиг хэрэг	12,880,205.00	8,608,950.00
210402	Тээвэр, шатахуун	43,266,324.00	29,559,372.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,762,271.20	2,536,851.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,142,250.00	7,623,950.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	97,670,295.28
2105	Нормативт зардал	543,940,015.22	552,448,717.73
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	543,940,015.22	552,448,717.73
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,608,300.00	6,546,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	80,000.00	00.00
210604	Урсгал засвар	13,528,300.00	6,546,100.00
2107	Томилолт, зочны зардал	15,253,100.00	6,248,000.00
210702	Дотоод албан томилолт	15,253,100.00	6,248,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,019,385.00	28,558,095.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,832,000.00	21,153,925.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,925.00	241,110.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	168,660.00	178,260.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,436,800.00	5,102,100.00
210807	Газрын төлбөр	326,000.00	327,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	343,697,480.05	137,925,605.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	160,088,250.00	6,078,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	99,026,200.00	47,248,075.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,583,030.05	84,599,530.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,548,119,198.90	2,400,458,907.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,454,696,764.00	2,388,383,538.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	170,520,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,040,565,694.00	1,136,635,744.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх	1,393,223,370.00	1,074,839,394.00

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

	дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,907,700.00	6,388,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	91,010,487.52	12,075,369.02
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	91,010,487.52	12,075,369.02
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,384,297.38	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,384,297.38	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,650.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,650.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	336,147,207.25	-100,545,662.49
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	241,647,566.90	182,167,915.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	241,647,566.90	182,167,915.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-241,647,566.90	-182,167,915.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	94,499,640.35	-282,713,577.49

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,661,504,171.04	4,353,934,867.07
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,661,504,171.04	4,353,934,867.07
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,449,862,806.00	3,969,823,741.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,449,862,806.00	3,969,823,741.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	211,641,365.04	384,111,126.07
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	31,014,900.00	31,106,136.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	61,144,990.50	207,811,511.03
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	91,929,477.64	123,258,954.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,551,996.90	21,934,524.54
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,678,115,671.04	4,188,613,367.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,678,115,671.04	4,188,613,367.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,117,308,300.60	1,780,770,655.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,194,240,543.00	1,358,310,352.05
210101	Үндсэн цалин	631,894,026.41	725,948,716.23
210102	Нэмэгдэл	356,587,315.73	412,837,591.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	88,263,173.46	88,942,255.49
210104	Урамшуулал	117,496,027.40	130,581,789.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	150,300,388.14	156,056,221.13
210201	Тэтгэврийн даатгал	101,861,330.78	107,091,921.13
210202	Тэтгэмжийн даатгал	12,238,474.76	12,235,400.00

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан			
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,126,147.43	6,169,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,598,767.07	6,111,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,475,668.10	24,447,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,734,652.26	112,856,546.87
210301	Гэрэл, цахилгаан	8,062,484.26	8,638,322.87
210302	Түлш, халаалт	65,978,880.00	84,459,936.00
210303	Цэвэр, бохир ус	20,693,288.00	19,758,288.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,376,971.20	27,049,590.00
210401	Бичиг хэрэг	3,600,000.00	5,768,075.00
210402	Тээвэр, шатахуун	31,479,600.00	13,937,864.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,762,271.20	2,173,851.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,335,100.00	3,869,800.00
2105	Нормативт зардал	21,881,253.00	10,044,325.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,881,253.00	10,044,325.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	304,737,600.00	10,508,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	287,241,800.00	00.00
210604	Урсгал засвар	17,495,800.00	10,508,300.00
2107	Томилолт, зочны зардал	15,253,100.00	6,248,000.00
210702	Дотоод албан томилолт	15,253,100.00	6,248,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,449,038.00	37,632,386.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,961,253.00	30,602,316.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,925.00	241,110.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	168,660.00	178,260.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,737,200.00	4,774,400.00
210807	Газрын төлбөр	326,000.00	281,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	266,334,755.00	62,064,934.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	163,033,555.00	7,485,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	103,301,200.00	54,579,834.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,560,807,370.44	2,407,842,712.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,456,896,764.00	2,388,823,544.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	170,520,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,051,226,068.00	1,136,635,744.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,382,562,996.00	1,074,789,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,107,700.00	6,878,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	91,010,487.52	19,019,168.02

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан			
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	91,010,487.52	19,019,168.02
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,384,297.38	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,384,297.38	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,515,821.54	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,515,821.54	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>-16,611,500.00</u>	<u>165,321,500.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,800,000.00	169,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,800,000.00	169,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,800,000.00	169,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,800,000.00	169,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-1,800,000.00</u>	<u>-169,000,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-18,411,500.00	-3,678,500.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,090,000.00	3,678,500.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,678,500.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	217,355,999.23	00.00	1,728,690,887.22
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	217,355,999.23	00.00	1,728,690,887.22
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-328,482,048.67	00.00	-328,482,048.67
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	-16,626,409.09	00.00	1,494,708,478.90
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	-16,626,409.09	00.00	1,494,708,478.90
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,533,025.26	00.00	1,533,025.26
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	-15,093,383.83	00.00	1,496,241,504.16
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний	00.00	-1,533,025.26	00.00	00.00	-1,533,025.26
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-282,713,577.49	00.00	-282,713,577.49
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	755,146,079.04	754,655,783.69	-297,806,961.32	00.00	1,211,994,901.41

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,093,969,200.00	3,969,823,741.00	124,145,459.00	97.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,093,969,200.00	3,969,823,741.00	124,145,459.00	97.0
Улсын төсвөөс санхүүжих	4,093,969,200.00	3,969,823,741.00	124,145,459.00	97.0
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,093,969,200.00	3,957,750,873.52	136,218,326.48	96.7
УРСГАЛ ЗАРДАЛ	4,093,969,200.00	3,957,750,873.52	136,218,326.48	96.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,620,288,500.00	1,574,367,329.52	45,921,170.48	97.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,252,880,300.00	1,247,733,401.52	5,146,898.48	99.6
Үндсэн цалин	736,768,000.00	725,948,716.23	10,819,283.77	98.5
Нэмэгдэл	324,774,700.00	302,260,640.80	22,514,059.20	93.1
Унаа хоолны хөнгөлөлт	67,104,900.00	88,942,255.49	-21,837,355.49	132.5
Урамшуулал	124,232,700.00	130,581,789.00	-6,349,089.00	105.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156,478,800.00	156,056,221.13	422,578.87	99.7
Тэтгэврийн даатгал	107,514,500.00	107,091,921.13	422,578.87	99.6
Тэтгэмжийн даатгал	12,235,400.00	12,235,400.00	0.00	100.0
ҮОМШӨ-ний даатгал	6,169,700.00	6,169,700.00	0.00	100.0
Ажилгүйдлийн даатгал	6,111,800.00	6,111,800.00	0.00	100.0
Эрүүл мэндийн даатгал	24,447,400.00	24,447,400.00	0.00	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,545,600.00	112,856,546.87	9,689,053.13	92.1
Гэрэл, цахилгаан	12,107,400.00	8,638,322.87	3,469,077.13	71.3
Түлш, халаалт	90,720,000.00	84,459,936.00	6,260,064.00	93.1
Цэвэр, бохир ус	19,718,200.00	19,758,288.00	-40,088.00	100.2
Хангамж, бараа материалын зардал	32,917,700.00	27,049,590.00	5,868,110.00	82.2
Бичиг хэрэг	3,081,400.00	5,768,075.00	-2,686,675.00	187.2
Тээвэр, шатахуун	24,929,400.00	13,937,864.00	10,991,536.00	55.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,662,000.00	2,173,851.00	-511,851.00	130.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	542,900.00	1,300,000.00	-757,100.00	239.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,702,000.00	3,869,800.00	-1,167,800.00	143.2
Нормативт зардал	6,500,000.00	00.00	6,500,000.00	0.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,500,000.00	00.00	6,500,000.00	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	10,509,300.00	10,508,300.00	1,000.00	100.0

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Урсгал засвар	10,509,300.00	10,508,300.00	1,000.00	100.0
Томилолт, зочны зардал	23,115,200.00	6,248,000.00	16,867,200.00	27.0
Дотоод албан томилолт	23,115,200.00	6,248,000.00	16,867,200.00	27.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,438,000.00	7,030,070.00	1,407,930.00	83.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,564,000.00	1,500,000.00	64,000.00	95.9
Даатгалын үйлчилгээ	278,100.00	241,110.00	36,990.00	86.7
Тээврийн хэрэгслийн татвар	207,500.00	178,260.00	29,240.00	85.9
Тээврийн хэрэгслийн оношлогоо	57,100.00	55,000.00	2,100.00	96.3
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,050,000.00	4,774,400.00	1,275,600.00	78.9
Газрын төлбөр	281,300.00	281,300.00	0.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	6,903,600.00	6,885,200.00	18,400.00	99.7
Бараа үйлчилгээний бусад зардал	6,723,600.00	6,705,200.00	18,400.00	99.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	180,000.00	180,000.00	0.00	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,473,680,700.00	2,383,383,544.00	90,297,156.00	96.3
Бусад урсгал шилжүүлэг	2,473,680,700.00	2,383,383,544.00	90,297,156.00	96.3
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	170,520,000.00	170,520,000.00	0.00	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,226,932,900.00	1,136,635,744.00	90,297,156.00	92.6
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,074,789,400.00	1,074,789,400.00	0.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,438,400.00	1,438,400.00	0.00	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	49	40	9	81.6
Удирдах ажилтан	1	1	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	40	31	9	77.5
Үйлчлэх ажилтан	8	8	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	381,111,126.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	381,111,126.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	381,111,126.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	110,576,950.53
210102	Нэмэгдэл	110,576,950.53
2105	Нормативт зардал	10,044,325.00

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан		
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,044,325.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,602,316.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,602,316.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	224,179,734.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	169,779,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	54,399,834.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	5,707,800.54
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	381,111,126.07
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	381,111,126.07
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	31,106,136.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	207,811,511.03
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	123,258,954.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,934,524.54
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үр дүнг нэгтгэв.

1. Бүтэц орон тоог аймгийн ЭМГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар удирдах 1, гүйцэтгэх 40, үйлчлэх 8, нийт 49 орон тоог баталсан бөгөөд 44 орон тоотой ажиллаж байгаад 2025 оны 3 дугаар сард 1, 9 дүгээр сард 1, 12 дугаар сард 3 нийт 5 албан тушаалтан тэтгэвэрт гарч 1 гүйцэтгэх албан хаагчийн оронд 1 хүн томилж, даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилж, нярвын үүргийг хавсруулж 2 орон тоог царцааж, гүйцэтгэлээр тайлант оны эцэст 40 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

2. Тус байгууллагын төсөвт хоолны зардлыг 67,104.9 мянган төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 88,942.3 мянган төгрөгийг зарцуулсан ба Засгийн газрын Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.4 дэх заалтыг үндэслэн өдрийн 10.0 мянган төгрөгөөр тооцон олгосон байна. Зардал хэтэрсэн нь тодотгол хийгдэж төсөв хасагдсантай холбоотой байна.

3. Сургалт, семинарын 2,726.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд тайлант онд 4 төрлийн сургалтыг зохин байгуулж 2,726.0 мянган төгрөгийг зарцуулсан байна

4. Тайлант онд эрүүл мэндийн боловсрол олгох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд “МТД” телевизтэй 3,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, эрүүл мэндийн боловсрол олгох, урьдчилан сэргийлэх мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэн ажилласан бөгөөд гэрээг хугацаанд нь биелүүлж, үр дүнг дүгнэн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

5. Тус байгууллага нь Санхүүгийн тооцоолох төвийн “Acolous” программыг санхүүгийн үйл ажиллагааг бүртгэж, тайлагнахад ашигладаг, тус программ нь биет бус хөрөнгийн дансанд 550.0 мянган төгрөгөөр бүртгэлтэй ба тайлант онд программын сунгалт, оны архив үүсгэх зардалд 1,430.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 473,674.7 мянган төгрөгийн 5 зөрчил¹ илэрснээс, 2,2551.3 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 471,123.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 460,464.1 мянган төгрөг нь нийцлийн аудитын зөрчил ба 13,210.6 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 31,304.8 мянган төгрөгийн гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 18,094.2 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1. Даргын 2025.01.31-ний өдрийн “Автомашинь торгууль төлөх тухай” А/13 дугаар тушаалаар тээврийн хэрэгслийн торгуульд 300.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан 300.0 мянган төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнаар төсөвт төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.2. Даргын 2025.01.02-ны өдрийн “Албан хаагчдын орон тоо, ангилал, зэрэглэл, цалин шинэчлэн тогтоох тухай” А/01 тоот тушаалаар ёс зүйн хорооны нарийн бичгийн даргад 10 хувиар тооцон нэмэгдэл олгохоор шийдвэрлэсэн байхад 20 хувиар тооцон 1,264.7 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нэмэгдэлд илүү олгосон 1,264.7 мянган төгрөгийг төсөвт төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.3. Тайлант онд 3 албан хаагчид 48 цагийн 853.6 мянган төгрөгийг илүү ологосон, дарга илүү цагийг биеэр амруулахаар шийдвэрлэсэн байхад 1 албан хаагчид 7 цагийн 133.0 мянга, нийт 55 цагийн 986.6 мянган төгрөгийг илүү олгосон

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 382 дугаар тушаалын 2 дугаар хаврлатаар баталсан

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

"Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 4.3-т "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү цагийн хөлсөнд илүү олгосон 986.6 мянган төгрөгийг төсөвт төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

3.2.1. Даргын 2024.06.27-ны өдрийн "Ёс зүйн дэд хороо байгуулах тухай" А/74 дүгээр тушаалаар ёс зүйн дэд хорооны 5 албан хаагчид 6, 10 дугаар сард нийт 7,920.0 мянган төгрөг, даргын 2025.01.02-ны өдрийн "Албан хаагчдын орон тоо, ангилал, зэрэглэл, цалин шинэчлэн тогтоох тухай" А/01 тоот тушаалаар сар бүр 20 хувь буюу 2,739.3 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг өгөв.

3.2.2. Эрүүл мэндийн системийн 2 байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй, хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг зөрчил илэрсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг өгөв.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Даргын 2025.01.31-ний өдрийн “Автомашинь торгууль төлөх тухай” А/13 дугаар тушаалаар тээврийн хэрэгслийн торгуульд 300.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас төлсөн байна.	1	300.0	1	300.0	-	-	-	-		
Даргын 2025.01.02-ны өдрийн “Албан хаагчдын орон тоо, ангилал, зэрэглэл, цалин шинэчлэн тогтоох тухай” А/01 тоот тушаалаар ёс зүйн хорооны нарийн бичгийн даргад 10 хувиар тооцон нэмэгдэл олгохоор шийдвэрлэсэн байхад 20 хувиар тооцон 1,264.7 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	1,264.7	1	1,264.7	-	-	-	-		
Даргын 2024.06.27-ны өдрийн “Ёс зүйн дэд хороо байгуулах тухай” А/74 дүгээр тушаалаар ёс зүйн дэд хорооны 5 албан хаагчид 6, 10 дугаар сард нийт 7,920.0 мянган төгрөг, даргын 2025.01.02-ны өдрийн “Албан хаагчдын орон тоо, ангилал, зэрэглэл, цалин шинэчлэн тогтоох тухай” А/01 тоот тушаалаар сар бүр 20 хувь буюу 2,739.3 мянган төгрөгийг олгосон байна.	1	10,695.3	-	-	1	10,695.3	-	-		

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Тайлант онд 3 албан хаагчид 66 цагийн 1,321.0 мянган төгрөгийг илүү олгосон, дарга илүү цагийг биеэр амруулахаар шийдвэрлэсэн байхад 1 албан хаагчид 7 цагийн 133.0 мянга, нийт 71 цагийн 1,454.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	986.6	1	986.6	-	-	-	-		
Дүн	4	13,210.6	3	2,551.3	1	10,695.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Эрүүл мэндийн системийн 2 байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй, хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг зөрчил илэрсэн байна.	1	460,464.1	-	-	1	460,464.1	-	-		
Дүн	1	460,464.1	-	-	1	460,464.1	-	-	-	-

-----oOo-----